

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/6/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2022 оны 02 дугаар сар</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: myangnboom@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.22 № 2/56

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

005020342

D:\alban bichig\A4-toot.docx

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОВ

Б.МӨНХБАТ

A red rectangular official stamp of the State Audit Agency of Mongolia. The stamp contains the Mongolian text "МОНГОЛЫН АУДИТЫН АГЫН ГЭР" (State Audit Agency of Mongolia) and "УЛААНБААТАР" (Ulaanbaatar). A black ink signature is written over the stamp.

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>52,863,855.67</u>	<u>61,443,223.67</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	52,863,855.67	61,443,223.67
351	Түүхий эд материал	11,919,995.12	19,396,863.12
35110	Тусгай зориулалттай материал	10,412,756.12	15,832,618.12
35130	Эм боох материал	1,507,239.00	3,564,245.00
354	Хангамжийн материал	40,943,860.55	42,046,360.55
35410	Бичиг хэргийн материал	1,231,400.00	1,795,600.00
35420	Аж ахуйн материал	2,381,000.00	1,481,400.00
35450	Барилгын засварын материал	2,505,000.00	1,620,500.00
35460	Хүнсний материал	3,348,785.00	1,567,095.00
35470	Бусад хангамжийн материал	31,477,675.55	35,581,765.55
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>684,080,320.14</u>	<u>654,545,734.20</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	684,080,320.14	654,545,734.20
392	Биет хөрөнгө	540,130,320.14	510,595,734.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	563,380,074.80	563,380,074.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-50,533,414.07	-75,146,454.35
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	53,812,950.64	56,087,950.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,566,548.75	-42,264,446.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,901,050.13	29,901,050.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,493,728.92	-24,086,625.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,146,016.00	8,146,016.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,825,100.69	-6,030,852.33
39217	Ном	309,021.00	609,021.00
393	Биет бус хөрөнгө	143,950,000.00	143,950,000.00
39301	Програм хангамж	225,000.00	225,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-225,000.00	-225,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	143,950,000.00	143,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>736,944,175.81</u>	<u>715,988,957.87</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>736,944,175.81</u>	<u>715,988,957.87</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	736,944,175.81	715,988,957.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	327,171,843.00	327,171,843.00
51101	Өмч: - төрийн	327,171,843.00	327,171,843.00
512	Хуримтлагдсан үр дүн	-56,249,350.25	-77,204,568.19
51210	Өмнөх үеийн үр дүн	-56,249,350.25	-56,249,350.25
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-20,955,217.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	466,021,683.06	466,021,683.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>736,944,175.81</u>	<u>715,988,957.87</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	339,686,800.00	375,989,253.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,388,500.00	8,104,762.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,388,500.00	8,104,762.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,388,500.00	8,104,762.00
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	00.00	2,275,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	00.00	5,829,762.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	334,298,300.00	367,884,491.15
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	289,394,200.00	312,993,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	289,394,200.00	312,993,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	10,009,340.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,009,340.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,904,100.00	44,881,951.15
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,904,100.00	44,881,951.15
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	352,315,367.21	386,935,131.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,315,367.21	386,935,131.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346,160,990.81	373,391,882.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,755,870.30	234,419,687.64
210101	Үндсэн цалин	176,554,170.30	194,844,787.64
210102	Нэмэгдэл	20,599,700.00	19,621,100.00
210104	Урамшуулал	15,602,000.00	19,953,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,000,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,163,799.30	29,236,408.70
210201	Тэтгэврийн даатгал	18,471,399.30	20,187,208.70
210202	Тэтгэмжийн даатгал	2,173,100.00	2,262,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,738,500.00	1,809,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	434,600.00	452,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,346,200.00	4,524,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,359,776.00	40,981,951.15
210301	Гэрэл, цахилгаан	2,365,135.00	1,847,510.15
210302	Түлш, халаалт	32,473,425.00	32,473,425.00
210303	Цэвэр, бохир ус	7,521,216.00	6,661,016.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,445,508.00	17,262,941.00
210401	Бичиг хэрэг	587,100.00	1,207,000.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	720,055.00	666,141.00
210404	Ном, хэвлэл	15,100.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	784,153.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,739,100.00	4,881,200.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	6,671,310.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	00.00	2,387,290.00
2105	Нормативт зардал	21,451,216.15	10,563,664.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	721,661.00	1,502,694.00
210502	Хоол, хүнс	20,729,555.15	8,598,470.00

**Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	462,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,303,200.00	5,720,700.00
210604	Урсгал засвар	1,303,200.00	5,720,700.00
2107	Томилолт, зочны зардал	84,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	84,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	823,300.00	982,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	573,300.00	401,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	231,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,774,321.06	34,223,729.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	180,000.00	694,144.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,173,800.00	1,420,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,420,521.06	32,109,585.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,908,796.40	23,552,588.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,754,600.00	10,009,340.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,754,600.00	10,009,340.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,544,324.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,544,324.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,610,052.40	13,543,248.66
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,610,052.40	13,543,248.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-12,628,567.21	-20,955,217.94
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-12,628,567.21	-20,955,217.94

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	183,221,843.00	243,463,660.00	-64,809,147.18	361,876,355.82
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	183,221,843.00	243,463,660.00	-64,809,147.18	361,876,355.82
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	40,205,323.24	40,205,323.24
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,171,843.00	466,021,683.06	-56,249,350.25	736,944,175.81
D01	2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,171,843.00	466,021,683.06	-56,249,350.25	736,944,175.81
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,171,843.00	466,021,683.06	-56,249,350.25	736,944,175.81
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-20,955,217.94	-20,955,217.94
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,171,843.00	466,021,683.06	-77,204,568.19	715,988,957.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	334,298,300.00	367,884,491.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	334,298,300.00	367,884,491.15
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	289,394,200.00	312,993,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	10,009,340.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,009,340.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,904,100.00	44,881,951.15
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,904,100.00	44,881,951.15
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	336,033,000.00	367,584,491.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	336,033,000.00	367,584,491.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	322,124,023.60	344,031,902.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,755,870.30	233,005,192.59
210101	Үндсэн цалин	176,554,170.30	193,430,292.59
210102	Нэмэгдэл	20,599,700.00	19,621,100.00
210104	Урамшуулал	15,602,000.00	19,953,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,000,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,163,799.30	30,650,903.75
210202	Тэтгэмжийн даатгал	2,173,100.00	2,262,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,738,500.00	1,809,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	434,600.00	452,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,346,200.00	4,524,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,359,776.00	40,981,951.15
210301	Гэрэл, цахилгаан	2,365,135.00	1,847,510.15
210302	Түлш, халаалт	32,473,425.00	32,473,425.00
210303	Цэвэр, бохир ус	7,521,216.00	6,661,016.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,099,608.00	9,377,741.00
210401	Бичиг хэрэг	1,212,000.00	2,192,800.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	720,055.00	666,141.00
210404	Ном, хэвлэл	60,200.00	221,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	784,153.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,723,200.00	4,847,200.00
2105	Нормативт зардал	25,479,670.00	17,194,670.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,056,200.00	2,728,100.00
210502	Хоол, хүнс	20,723,270.00	9,204,070.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,700,200.00	5,262,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,184,200.00	7,178,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,120,000.00
210604	Урсгал засвар	2,184,200.00	6,058,200.00
2107	Томилолт, зочны зардал	84,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	84,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	823,300.00	1,183,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	573,300.00	593,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	350,000.00

**Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,173,800.00	4,459,444.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	3,634,144.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,173,800.00	825,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,908,976.40	23,552,588.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,754,600.00	10,009,340.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,754,600.00	10,009,340.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,544,324.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,544,324.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,610,052.40	13,543,248.66
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,610,052.40	13,543,248.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>6,019,900.00</u>	<u>300,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>6,019,900.00</u>	<u>300,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>6,019,900.00</u>	<u>300,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	6,019,900.00	300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,019,900.00	300,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-6,019,900.00</u>	<u>-300,000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	358,446,900.00	344,331,902.49	14,114,997.51	96.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	358,446,900.00	344,331,902.49	14,114,997.51	96.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	358,446,900.00	344,331,902.49	14,114,997.51	96.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237,229,400.00	233,005,192.59	4,224,207.41	98.22
210101	Үндсэн цалин	197,654,500.00	193,430,292.59	4,224,207.41	97.86
210102	Нэмэгдэл	19,621,100.00	19,621,100.00	0.00	100.00
210104	Урамшуулал	19,953,800.00	19,953,800.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,041,000.00	30,650,903.75	390,096.25	98.74
210201	Тэтгэврийн даатгал	21,991,800.00	21,601,703.75	390,096.25	98.23
210202	Тэтгэмжийн даатгал	2,262,300.00	2,262,300.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,809,800.00	1,809,800.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	452,500.00	452,500.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,524,600.00	4,524,600.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,553,700.00	40,981,951.15	571,748.85	98.62
210301	Гэрэл, цахилгаан	2,505,300.00	1,847,510.15	657,789.85	73.74

**Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	32,387,400.00	32,473,425.00	-86,025.00	100.27
210303	Цэвэр, бохир ус	6,661,000.00	6,661,016.00	-16.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,784,100.00	9,677,741.00	106,359.00	98.91
210401	Бичиг хэрэг	2,192,800.00	2,192,800.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	722,500.00	666,141.00	56,359.00	92.20
210404	Ном, хэвлэл	521,600.00	521,600.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	450,000.00	50,000.00	90.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,847,200.00	4,847,200.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	26,016,400.00	17,194,670.00	8,821,730.00	66.09
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,728,100.00	2,728,100.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	18,025,800.00	9,204,070.00	8,821,730.00	51.06
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,262,500.00	5,262,500.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,178,200.00	7,178,200.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,120,000.00	1,120,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	6,058,200.00	6,058,200.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,183,800.00	1,183,800.00	0.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	593,800.00	593,800.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4460300.00	4459444.00	856.00	99.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,635,000.00	3,634,144.00	856.00	99.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	825,300.00	825,300.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	358,446,900.00	344,331,902.49	14,114,997.51	96.06
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	312,993,200.00	299,449,951.34	13,543,248.66	95.67
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	312,993,200.00	299,449,951.34	13,543,248.66	95.67
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,453,700.00	44,881,951.15	571,748.85	98.74
132001	Орон нутгийн төсвөөс	45,453,700.00	44,881,951.15	571,748.85	98.74
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	20.00	20.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00	0.00	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	94.00	94.00	0.00	100.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	94.00	94.00	0.00	100.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	94.00	94.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20.00	20.00	0.00	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	10.00	10.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,009,340.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,009,340.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,009,340.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,009,340.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,009,340.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,009,340.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,009,340.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,009,340.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа бараа материалын үнийг тодорхой тусгах, онцгой комиссоос олгож байгаа зардлын анхан шатны баримтын бүрдэлд хяналт тавих, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын шийдвэрийг бүрэн байршуулах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Ч.Баярсайхан, 2 дугаар гарын үсгийг Д.Баатар нар зурж, нярваар Н.Уранчимэг ажиллажээ.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэг нь "Сургалтын чанарыг сайжруулах, эрүүл аюулгүй орчин сурч хөгжих боломжийг хангах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих ээлтэй орчныг бүрдүүлэх, авьяас чадварыг байнга хөгжүүлэх секц дугуйлан бэлтгэх зэрэг 5 зорилтыг тайлант онд дэвшүүлэн, 20 орон тоотой ажиллаж, дунд бүлэгт 23, ахлах бүлэгт 38, бэлтгэл бүлэгт 33, нийт 94 хүүхэд хамрагдахаас танхимаар 32, цахимаар 62 хүүхэд хамруулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын 2018.04.27-ний өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй, бусад хяналт шалгалтын байгууллагуудаас шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн

тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 352,315.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,523.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,818.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 386,935.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,869.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3,095.5 мянган төгрөг байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 715,989.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 20,955.2 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52,863.9	61,443.2	8,579.4
Бараа материал	52,863.9	61,443.2	8,579.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	684,080.3	654,545.7	(29,534.6)
Үндсэн хөрөнгө	799,724.1	802,299.1	2,575.0
Хуримтлагдсан элэгдэл	(115,643.8)	(147,753.4)	(32,109.6)
Нийт хөрөнгө	736,944.2	715,989.0	(20,955.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	736,944.2	715,989.0	(20,955.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	736,944.2	715,989.0	(20,955.2)

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны 2 харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 61,443.2 мянган төгрөг болж өмнөх оноос 8,579.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 36,885.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 5,829.7 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авч, үйл ажиллагаандаа 25,076.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, байгууллагын даргын 2021.11.22-ний өдрийн Б/25 дугаар тушаалаар 6,671.3 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг акталж, Баянхонгор сумын Засаг даргын захирамжаар Баян-Ойт цэцэрлэгт 2,387.3 мянган төгрөгийн хүнсний материалыг шилжүүлсэн байна.

Оны эхэнд бүртгэлтэй 799,724.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж төсвийн хөрөнгөөр 300.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг худалдан авч, орлогоор бүртгэн, аймгийн ЗДТГ-аас 550.0 мянган төгрөгийн өнгөт принтер, 1,725.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер ирснийг хөрөнгөд бүртгэснээр оны эцэст 802,299.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 20,955.2 мянган төгрөгөөр буурч 715,988.9 мянган төгрөг болсон байна.

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэг улсын төсвөөс авах санхүүжилт өмнөх оноос 24,148.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, 344,331.9 мянган төгрөг болсон нь цалингийн зардал, хангамж, бараа материалын зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн өөрчлөгдөөгүй бөгөөд тайлант жилийн үр дүн тайлангуудад зөв бүртгэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэг 2021 оны төсвийн төлөвлөлтийг 407,714.0 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70106, 71801 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэх төсвийн хуваарийг анх 371,360.4 мянган төгрөгөөр баталсан ба тайлант хугацаанд 2021 оны 7 дугаар сард 363,528.4 мянга, 11 дүгээр сард 358,446.9 мянган төгрөг болж, анх батлагдсан төсвөөс 12,913.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Анхны батлагдсан төсөв	2021 оны 12 сард хийсэн тодотгосон төсөв
371,360.4	358,446.9

Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэг өөрийн орлогын төлөвлөгөөгүй, тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр авахаар батлагдсан 312,993.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн, орон нутгийн төсвөөс авахаар батлагдсан 45,453.7 мянган төгрөгийг 571,7 мянган төгрөгөөр дутуу авч, нийт 357,875.1 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 344,331.9 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 13,543.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 2 албан хаагчийн 5 жилийн тэтгэмжид 10,009.4 мянган төгрөгийн орлого орсныг албан хаагчдад олгосон байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны 12 дугаар сард хоолны зардлын хэмнэлтийн 6,382.5 мянга, шуудан холбооны зардлын хэмнэлтийн 56.4 мянга, нийт 6,438.9 мянган төгрөгөөс 4,900.0 мянган төгрөгийг зөөлөн эдлэл авахад, 1,380.0 мянган төгрөгийг ковидын 100 ширхэг тест авахад зарцуулахаар төсөвт зохицуулалт хийсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 стратеги зорилтын хүрээнд 32 арга хэмжээ тусгагдаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 87 хувиар тайлагнаж, дээд шатны байгууллагаас үнэлээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалган, мэдээлээгүй мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх зөвлөмжийг шалгагдагч байгууллагын удирдлагад хүргүүлэв.

Тус байгууллага нь 2021 онд нийт 456,136.5 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхийг бүрэн мэдээлсэн, мэдээлбэл зохих 149 мэдээллээс 467,584.4 мянган төгрөгийн 147 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 11,447.8 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, ТБОНӨХБАҮХАТХ болон Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын зарим чиглэлийг хэрэгжүүлж ажиллаагүй нь холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэн зөвлөмжийг хүргүүлэв.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, менежментийн захидлаар 3 зөвлөмж өгч, шалгагдагч байгууллага зөвлөмжийн биелэлтийг 2021.05.24-ний өдрийн 40 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ковид цар тахлын үед тусгаарлах гэрт дулаалгын багц авсан гэрээ байгуулсан атлаа төлбөрийг төлөөгүй байгаа тул энэ асуудлыг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,457.2 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, санхүүгийн тайланд 10,009.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 11,447.8 мянган төгрөгийн зөрчилд байгууллагын удирдлагад 3 зөвлөмжийг хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Нэмэлт санхүүжилтийн дансанд 2 албан хаагчийн 5 жилийн тэтгэмжид 10,009.4 мянган төгрөгийн орлого орж, албан хаагчдад олгосныг үр дүнгийн тайланд тайлагнаагүй тул санхүүгийн тайланд орлого, зардлаар бүртгэж, үр дүнгийн тайланг залруулав.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Балансын данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

“Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.8 дахь “Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах”, 1.9 дэх “Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах” заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

2. **Зардлын холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын даргын тушаалаар 6,671.0 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө актлахдаа тушаалын хавсралтыг бэлтгээгүй, устгал хийсэн баримт үйлдээгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийн дагуу актлах хөрөнгийн жагсаалтыг байгууллагын даргын тушаалаар баталж, устгал хийсэн баримтыг үйлдэж, санхүүгийн баримтад хавсаргах

3. **Зардлын холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 6,494.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, байгууллагын даргын 2021.09.14-ний өдрийн 4,953.1 мянган төгрөгийг захиран зарцуулах Б/20 дугаар тушаалыг байршуулаагүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж, дутуу байршуулсан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нөхөн мэдээлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэг	4	21,457.2	1	10009.4	0	0	0	0.00	3	11,447.8

---oOo---